

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234720

МИНЬХЭ МОНГОР ХЭЛНИЙ *ki- ҮЙЛ ҮГИЙН ТҮҮХЭН ХУВЬСЛЫН
ТУХАЙ ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ БАЙДАЛТАЙ
ХАРЬЦУУЛАН ҮЗЭХ НЬ

Шиотани Шигэки¹

Хураангуй: Эртний монгол хэлэн дэх *ki- “хий-” хэлбэртэй үйл үг нь Миньхэ монгол хэлэнд хэрхэн хувьсаж ирснийг хэлний цуваа цагийн үүднээс судлахдаа орчин цагийн монгол хэлний байдалтай харьцуулан үзэж, хоёр хэлний адил ба ялгаатай талыг тодруулсан болно. Миньхэ монгол хэлэнд 1. Бие даасан үг буюу дан үгийн утгаар бол “ge-” [gə-] хэлбэрийг хэрэглэдэг байхад 2. Нэрээс үйл бүтээх дагавар буюу үүсмэл үгийн утгаар бол а. Хятад гаралтай үгэнд залгахдаа “-ke-” [-kə-] хэлбэрийг, б. Голдуу эрэгтэй хүн нь “-qi-” [-tɕi-] хэлбэрийг илүү хэрэглэдэг гэсэн өвөрмөц онцлогтой байгаа бөгөөд эдгээр нь цөм нэг л үйл үг *ki- хэлбэрээс гарал үүсэлтэй байх боломжтойг дурдахын зэрэгцээ, авиазүйн үүднээс үзэхэд 1. *ki- > ge- (Дуутай болсон нь), 2. *ki- > -ke- (Дуугүй хэвээр нь), 3. *ki- > -qi- (Тагнайшсан нь) гэсэн гурван өөр үе шатыг дамжин эдүгээгийн байдалд хүрсэн гэж дүгнэв.

Түлхүүр үг: Миньхэ монгол хэл, *ki- хэлбэртэй үйл үг, авианы хувьсал, бие даасан үг, үг бүтээх дагавар, орчин цагийн монгол хэл (Minhe Monguor language, the verb *ki-, phonological change, independent word, derivational suffixes, Modern Mongolian)

Эхлэл

Миньхэ монгол хэл¹ бол Хятадын Цинхай мужийн Миньхэ Хотон, Монгол үндэстний өөртөө засах шяны Гуантин балгас дахь монголчуудын ярьдаг хэл бөгөөд монголчууд нь түүхэндээ бичиг үсэг хэрэглэж байсангүй. Одоогоор тус хэлээр хэлэлцэгч арван мянга гаруй хүн байна гэсэн тооцоо бий.

Миньхэ монгол хэлний талаар Б.Х.Тодаева (1973), Dpal-ldan-bkra-shis, Keith W. Slater нар (1996), Keith W. Slater (2003a,b), Jiang Genxiong (2018) зэрэг судлаачийн ном бүтээл, өгүүлэл гарсан бөгөөд тэдгээрт одоогийн Миньхэ монгол хэлний төлөв байдлыг зохих хэмжээгээр товчоолон дурдсан байдаг.

¹ Монгол хэлийг *Миньхэ аялгуу*, *Хүжү аялгуу* гэгдэх хэлний хоёр аялгуутай гэж ихэнх судлаач үздэг. Гэвч үнэндээ авиазүй, үгзүй, хэлзүйн талаар харилцан зөрүү ихтэй, өөр хоорондоо бие биеэ ер ойлголцдоггүй тул монгол төрлийн бие даасан хоёр өөр хэл буюу *Миньхэ монгол хэл*, *Хүжү монгол хэл* гэж үзвэл зохино гэж бодож байна. Бидний ажигласнаар Миньхэ монгол хэлний онцлог нь Хүжү монгол хэлнээсээ Баоань, Дуншаан, Канжаа зэрэг гурван хэлэнд илүү ойр байгаа нь даруй хятад хэлний нөлөө их туссантай холбоотой буй за. Харин Хүжү монгол хэл нь төвд хэлний нөлөө их байгаагаараа онцлог юм.

Миньхэ монгол хэлний үйл үг бүтээх *ke-*, *ge-* дагаврын тухай Keith W. Slater (2003) дурдахдаа “Энэхүү дагавар нь монгол хэлний уугуул үгтэй цуг тохиолдохгүй, зээлдсэн үйл үг бүтээхэд л хэрэглэдэг бололтой юм. Жишээ нь: *kaike-* (эхлэх) < Ch. 开 *kai*,² *xiaoshunge-* (эцэг эхээ ачлах) < Ch. 孝顺 *xiaoshun* гэх мэт”³ гэжээ.

Бид энэхүү өгүүлэлдээ эртний монгол хэлэн дэх **ki-* “хий-” хэлбэртэй үйл үг нь Миньхэ монгол хэлэнд хэрхэн хувьсаж ирснийг хэлний цуваа цагийн үүднээс судлахын зэрэгцээ мөн орчин цагийн монгол хэлний байдалтай харьцуулан үзэж, хоёр хэлний адил ба ялгаатай талыг тодруулахыг зорилоо.

Миньхэ монгол хэлний бие даасан үйл үг *ge-* хэлбэрийн учир

Эртний монгол хэлний үйл үг **ki-* “хий-” хэлбэр нь Миньхэ монгол хэлэнд⁴ *ge-* [gə-] хэлбэртэй болсон бөгөөд энэ нь 1. *хий-* (Мо. *ki-*)⁵, 2. *гэ-* (Мо. *ge-*), 3. *гээ-* (“тавь-” гэсэн утгатай) (Мо. *gege-*) гэсэн гурван утгыг агуулсан *ижил дуудлагатай үгс* (homonyms) болж хувирсан байна.

1. *хий-* гэсэн утгатай жишээ нь:

qi yang ge-labi [tei jaŋ gə-labi] (Чи юу хийж байна?)

2. *гэ-* гэсэн утгатай жишээ нь:

qini niere yang ge-labi [teini niərə jaŋ gə-labi] (Чиний нэр юу (“хэн”) гэдэг вэ?)
ni kedu ge-labi [ni kədu gə-labi] (Энэ хэд гэж байна? “Энэ ямар үнэтэй вэ?”)

3. *гээ-* (“тавь-”) гэсэн утгатай жишээ нь:

tini ningdu ge [tini niŋdu gə] (Түүнийг энд тавь.)

Бидний үзэхээр эртний монгол хэлний **ki-*, **ge-* хоёр үйл үгийн аль аль нь ганц үетэй бөгөөд зөөлөн тагнайн гийгүүлэгч *k/g*, хэлний урдуурх эгшиг *i/e* гэх мэтээр авиалах байр нь харьцангуй ойрхон тул тус хоёр үйл үг хутгалдан ижилссэний улмаар Миньхэ монгол хэлэнд угийн урт эгшиг нь богиносдог дүрэмтэй⁶ учир үйл үг **gege-* ч **gege-* > *gē-* > *ge-* гэх мэтээр хувирч, дээрх хоёр үгтэй ижил дуудлагатай *ge-* [gə-] болсон байна.

Миньхэ монгол хэлний нэрээс үйл бүтээх *-ke-* дагаврын учир

Бидний судалснаар Миньхэ монгол хэлэнд 1. *-da-*, 2. *-la-* ~ *-luo-* ~ *-li-* (∞ *-lie-*), 3. *-ra-* ~ *-ruo-* ~ *-re-* (∞ *-ri-*), 4. *-tu-*, 5. *-ke-* гэсэн таван зүйлийн нэрээс үйл бүтээх дагавар байна⁷.

² Хятад гаралтай үгийг Ch. гэж товчлов.

³ Slater, Keith W. (2003a), *A Grammar of Mangghuer: A Mongolic language of China's Qinghai-Gansu Sprachbund*, х.114, Curzon, London.

⁴ Хүжү монгол хэлэнд ч гэсэн *gi-* хэлбэр 1. *хий-* (Мо. *ki-*), 2. *гэ-* (Мо. *ge-*) гэсэн ондоо утгыг агуулсан *ижил дуудлагатай үгс* болжээ.

⁵ Монгол бичгийн хэлийг энд Мо. гэж товчлов.

⁶ Орчин цагийн монгол хэлний урт эгшиг нь Миньхэ монгол хэлэнд голдуу богино эгшиг, хааяа хос эгшиг болсон буюу урт, богино эгшигийн ялгаа байхгүй болсон байна. Жишээ нь: *khuga* [qura] (1 хур “бороо”, 2 хураа- “хуримтуул-”), *diere* [diərə] (1 дээр, 2 дэр) гэх мэт.

⁷ Шиотани Шигэки (2023), Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын судалгаа, *Frontier of foreign*

Ер нь хятад гаралтай үгээс үйл үг үүсгэх монгол төрөл хэлнүүдэд нийтлэг байдаг дагавар гэвэл Мо. *-la-/-le-* бөгөөд Миньхэ монгол хэлэнд *-la- ~ -luo- ~ -li-* (∞ *-lie-*) хэлбэрээр тохиолдож байна⁸.

huang-la- [xuɑŋla-] (“завгүй байх”) < *huang* [xuɑŋ] (Ch. 慌 *huang* “сандрах”) *shua-la-* [ʃuɑla-] (“сойздох”) < *shua* [ʃuɑ] (Ch. 刷 *shua* “сойз”) *yangji-la-* [jaŋdʒila-] (“гуйх”) < *yangji* [jaŋdʒi] (Ch. 央求 *yangqiu* “гуйх”) *cuo-luo-* [tsuoluo-] (“андуурах”) < *cuo* [tsuo] (Ch. 错 *cuo* “буруу, алдаа”) *bian-li-* [bianli-] (“хувирах, өөрчлөгдөх”) < *bian* [bian] (Ch. 变 *bian* “хувирах”) *zheng-li-* [dzəŋli-] (жигнэх, Мо. *jingne-* (< **jing-le-*)) < *zheng* [dzəŋ] (Ch. 蒸 *zheng* “жигнэх”) *jie-lie-* [dʒiɛliɛ-] (зээлэх, Мо. *jigele-*) < *jie* [dʒiɛ] (Ch. 借 *jie* “зээлэх”) гэх мэт.

Гэвч Миньхэ монгол хэлэнд нэрээс үйл бүтээх өвөрмөц *-ke-* дагавар бий бөгөөд үүний тухай бид (2023) “Тус дагаврыг хятад гаралтай зарим үгэнд залгаж, тухайн үгийн утга бүхий үйл үг үүсгэнэ. Энэхүү үг бүтэх ёс нь орчин монгол хэлэнд ер харагддаггүй учир Миньхэ монгол хэлний өвөрмөц арга, нэг ёсны шинэчлэл гэж болох байна”⁹ гэж үзсэн билээ. Жишээ нь:

kai-ke- [kaikə-] (“эхлэх”) < *kai* [kai] (Ch. 开 *kai* “нээх”) *la-ke-* [lakə-] (“татах”) < *la* [la] (Ch. 拉 *la* “татах”) *ma-ke-* [makə-] (“арчих”) < *ma* [ma] (Ch. 抹 *ma* “арчих”) *tang-ke-* [taŋkə-] (“хэвтэх”) < *tang* [taŋ] (Ch. 躺 *tang* “хэвтэх”) *wa-ke-* [wakə-] (“малтах”) < *wa* [wa] (Ch. 挖 *wa* “малтах”) гэх мэт.

Энэхүү *-ke-* [-kə-] дагаврын гарал үүслийн тухайд гэвэл 1-рт дуудлагын хувьд зөөлөн тагнайн дуугүй гийгүүлэгч [k] авиаг хадгалж байгаа бөгөөд 2-рт хятад гаралтай ганц үетэй үгийг “үйл үг” болгож байгаа гэсэн хоёр шалтгаанаар **ki-* “хий-” хэлбэрээс үүссэн нь лавтай буй заа. Өөрөөр хэлбэл *Ch. + *ki-* (нийлмэл үг) > Ch.-*ke-* (үүсмэл үг) болж хувирсан болов уу гэж таамаглаж байна.

Миньхэ монгол хэлний нэрээс үйл бүтээх *-qi-* дагаврын учир

Бидний ажигласнаар Миньхэ монгол хэлний энэхүү дагаврын өвөрмөц онцлог гэвэл *-ke-* [-kə-] ~ *-qi-* [-tɕi-] хоёр дагаврын сэлгэлт бөгөөд Миньхэмонгол хэлээр яригч эрэгтэй хүн нь *-qi-* [-tɕi-] хэлбэрийг илүү их хэрэглэдэг бололтой¹⁰. Тус хэлний энэхүү үзэгдлийг бас л Миньхэ монгол хэлний нэг ёсны шинэчлэл гэж болох бөгөөд дотор нь хоёр хувааж болох байна.

1. Хятад гаралтай үгэнд *-ke-* ~ *-qi-* сэлгэсэн жишээ:

kai-ke- [kaikə-] (ерийн хэллэг) ~ *kai-qi-* [kaitɕi-] (эрэгтэй хүний хэллэг) (“эхлэх”)

< *kai* [kai] (Ch. 开 *kai* “нээх”)

la-ke- [lakə-] (ерийн хэллэг) ~ *la-qi-* [latɕi-] (эрэгтэй хүний хэллэг) (“татах”)

language education, Vol. 6, х.30-34, Осака.

⁸ Шиотани Шигэки (2023), Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын судалгаа, *Frontier of foreign language education*, Vol. 6, х.31-32, Осака.

⁹ Шиотани Шигэки (2023), Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын судалгаа, *Frontier of foreign language education*, Vol. 6, х.33, Осака.

¹⁰ Шиотани Шигэки (2023), Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын судалгаа, *Frontier of foreign language education*, Vol. 6, х.33-34, Осака.

< la [la] (Ch. 拉 la “татах”)

ma-ke- [makə-] (ерийн хэллэг) ~ ma-qi- [matei-] (эрэгтэй хүний хэллэг) (“арчих”) < ma [ma] (Ch. 抹 ma “арчих”)

tang-ke- [taŋkə-] (ерийн хэллэг) ~ tang-qi- [taŋtɕei-] (эрэгтэй хүний хэллэг) (“хэвтэх”) < tang [taŋ] (Ch. 躺 tang “хэвтэх”)

wa-ke- [wakə-] (ерийн хэллэг) ~ wa-qi- [watei-] (эрэгтэй хүний хэллэг) (“малтах”) < wa [wa] (Ch. 挖 wa “малтах”) гэх мэт.

Үүнийг “Ch. -ke- (ерийн хэллэг) ~ Ch. -qi- (эрэгтэй хүний хэллэг)” гэж загварчилж болох бөгөөд Миньхэ монгол хэлэнд нэлээн идэвхтэй хэрэглэдэг байна.

2. Монгол гаралтай -qi- төгсгөлтэй үгэнд -ke-тэй сэлгэсэн жишээ:

erqi- [ətɕei-] (эрэгтэй хүний хэллэг / “хөлс арчих” арчи-, Mo. arɕi-)

~ erke- [əkə-] (ерийн хэллэг)

nuoqi- [nuotɕei-] (эрэгтэй хүний хэллэг / “цаг өнгөрөх” нөгчи-, Mo. nögɕi-)

~ nuo-ke- [nuokə-] (ерийн хэллэг)

Үүнийг “M-qi- (эрэгтэй хүний хэллэг) → M-ke- (ерийн хэллэг)” гэж загварчилж болох¹¹ бөгөөд Миньхэ монгол хэлний цөөн тооны үйл үгэнд л тохиолдож байна.

Энэхүү “M-ke-” хэлбэр хэрхэн үүссэн тухайд гэвэл дээрх “Ch. -ke-” үүсмэл үгнээс -ke- ~ -qi- сэлгэж, “Ch. -qi-” үүсэн гарсны яг эсрэг явцаар буюу *урвуу аргаар үг бүтэх ёс* (back-formation)-оор буй болсон гэж тайлбарлаж болох байна.

Миньхэ монгол хэлний нэрээс үйл бүтээх энэхүү -qi- дагаврын гарал үүслийн талаар нягтлан үзвэл дээр 2-р бүлэгт дурдсанчлан нэг бол *ki- > -ke- [-kə-] болж хувирснаас гадна бас *ki- > -qi- [-tɕei-] болж хувирсан гэж үзвэл зохино.

Ер нь цуваа цагийн үүднээс үзэхэд Миньхэ монгол хэлэнд үгийн эхний хэлний гүн угийн болон гүн бус угийн дуугүй хамжих *q-, *k- гийгүүлэгч нь эгшиг *i-гийн өмнө тохиолдохдоо тагнайшиж qi- [tɕei-] болох дүрэмтэй¹² байдаг (# *qi-, *ki- > # qi- [tɕei-]) учир энэхүү *ki- дагавар ч тус дүрмийг дагаж, өөрөөр хэлбэл *адил төсийн хууль* буюу аналогор *ki- > -qi- [-tɕei-] болж хувирсан гэж үзэж байна.

Үгийн эхний *qi-, *ki- > qi- [tɕei-] болсон жишээ:

qirao [tɕirao] (хөрөө, Mo. kirüge)

qiduoghuo [tɕiduoguo] (хутга, Mo. kituya < *qituga)

qinpuzi [tɕimpudzi] (хумс, Mo. kimusu < *qimusu)

qidai [tɕidai] (хятад, Mo. kitad < *qitad)

qiergha- [tɕiə-ɕa-] “хайчла-” (хярга-, Mo. kirɣa- < *qirga-)

Миньхэ монгол хэлний үйл үг *ki- хэлбэрийн хувьсал

Миньхэ монгол хэлний үйл үг *ki- хэлбэрийн тухай дээр 1-ээс 3 хүртэл дурдсаныг хураангуйлбал доорх мэт:

1-р бүлгээс Миньхэ монгол хэлэнд үйл үг *ki- “хий-” хэлбэр нь ge- [gə-]

¹¹ Монгол гаралтай үгийг М гэж товчлов.

¹² Хааяа нэг ch- [tɕi-] болсон нь ч бий: # *qi-, *ki- > ch- [tɕi-], chiber [tɕibə] (хялбар, Mo. kilbar < *qilbar)

хэлбэрээр илэрдэг бөгөөд 1. *хий-* (Mo. *ki-*), 2. *гэ-* (Mo. *ge-*), 3. *гээ-* (“тавь-” гэсэн утгатай) (Mo. *gege-*) гэсэн гурван утгыг агуулсан үг болжээ.

2-р бүлгээс Миньхэ монгол хэлэнд хятад гаралтай үгээс үйл үг бүтээх *-la-* ~ *-luo-* ~ *-li-* (∞ *-lie-*) дагавар байхаас гадна, бас нэг өвөрмөц *-ke-* дагавар бий бөгөөд энэ нь үйл үг **ki-* “хий-” хэлбэрээс үүссэн нь лавтай байна.

3-р бүлгээс Миньхэ монгол хэлэнд хятад гаралтай үгээс үйл үг бүтээх *-ke-* [*-kə-*] дагавар нь *-qi-* [*-tɕi-*] дагавартай сэлгэдэг бөгөөд Миньхэ монгол хэлээр яригч эрэгтэй хүн нь *-qi-* [*-tɕi-*] хэлбэрийг илүүтэй хэрэглэдэг онцлогтой. Энэхүү *-qi-* [*-tɕi-*] дагавар ч үйл үг **ki-* “хий-” хэлбэрээс хувирч ирсэн бөгөөд үүнд *-qi-* төгсгөлтэй үгийг буцаад *-ke-* хэлбэрээр сольж хэлэх үзэгдэл ч гарч байна.

Бас үйл үг **ki-* хэлбэрийн хувьсал хөгжлийн явцыг авиазүй болон үгзүйн үүднээс хөөж үзвэл:

А. Бие даасан үгээр *ge-* [*gə-*] хэлбэрийг хэрэглэх нь:

**ki-* > ① *ge-* [*gə-*] (дуутай болсон)

Б. Дагаврын үүргээр *-ke-* [*-kə-*] ~ *-qi-* [*-tɕi-*] хоёр хэлбэрийг хэрэглэх нь:

**ki-* > ② *-ke-* [*-kə-*] (дуугүй хэвээрээ үлдсэн)

**ki-* > ③ *-qi-* [*-tɕi-*] (тагнайшсан)

Ер нь авианы түүхэн хувьслыг “ижил нөхцөл байдалд нэг цаг үед адилхан бий болно” гэж үзвэл дээрх авианы хувьслыг ② → ③ → ① гэсэн дэс дараагаар гурван өөр үе шатаар дамжиж үүссэн байх гэж таамаглаж болох байна.

Өөрөөр хэлбэл эхний үе шатанд “дагавар”-ын нөхцөл байдалд ихэнх **ki-* > ② *-ke-* [*-kə-*] гэх зэргээр дуугүй хэвээр нь үлдсэн, дараагийн үе шатанд зарим **ki-* > ③ *-qi-* [*-tɕi-*] гэх мэтээр дуугүй гийгүүлэгч *ki-* нь тагнайшиж *qi-* [*tɕi-*] болж хувирсан бөгөөд сүүлчийн үе шатанд бусад нөхцөлд буюу “бие даасан үг”-энд **ki-* > ① *ge-* [*gə-*] зэргээр дуутай болсон гэж тайлбарлаж болох байна.

Ялангуяа дагаврын **ki-* > ② *-ke-* [*-kə-*], бие даасан үгийн **ki-* > ① *ge-* [*gə-*] гэсэн хоёр авианы хувьсал үүссэн дэс дарааллын тухайд гэвэл ② → ① болсноос биш, **①* → ② гэж яасан ч болохгүй юм. Учир нь **ki-* > *-ke-* болсон хойно дуутай *ge-* болох боломж байхаас биш, **ki-* > *ge-* болсон хойно буцаад *ge-* нь дуугүй *-ke-* болох боломж үгүй гэж үзэж байна.

Орчин цагийн монгол хэлний байдал

Монгол хэлний нэрээс үйл бүтээх дагаврын учир

Бидний ажигласнаар орчин цагийн монгол хэлэнд 1. *-вчла-*, 2. *-да-*, 3. *-жи-* (∞ *-жира-*), 4. *-ла-* (~ *-на-*), 5. *-лда-*, 6. *-ра-* (~ *-ла-*), 7. *-рха-* (~ *-лха-*), 8. *-с-* (~ *-д-*), 9. *-с-*, 10. *-са-*, 11. *-та-*, 12. *-ца-*, 13. *-чи-*, 14. *-чла-*, 15. *-шаа-*, 16. *-ши-*, 17. *-шира-* гэх зэрэг нийтдээ арван долоон зүйлийн нэрээс үйл бүтээх дагавар байдаг¹³.

Эдгээрийн дотроос Алтай хэлний язгуурт нийтлэг буюу хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь 4. *-ла-* (~ *-на-* /*м#*_, *н(г)г#*_)¹⁴ дагавар мөн бөгөөд энэ нь

¹³ Шиотани Шигэки (2009), Монгол хэлний халхын аялгуун дахь үг бүтээх дагаврын судалгаа (Засварласан хэвлэл), Осака.

¹⁴ Орчин цагийн монгол хэлэнд нэр үгийн *м#*_ эсвэл *н(г)г#*_ (заримдаа *н#*_) төгсгөлтэй үгэнд *-ла-* дагавар залгахдаа энэхүү *-ла-* нь *-на-* болж хувирах ерөнхий дүрэмтэй байдаг. Үүнд *-m.l-* > *-m-n-* (by assimilation) / *-ŋ.l-* (~ *-n.l-*) > *-ŋ.n-* (by assimilation) > *-g.n-* (by dissimilation).

нэлээн дээр үеэс хятад гаралтай ганц үетэй үгэнд ч цөөнгүй залгагдаж байсан бололтой.

Хятад гаралтай үгэнд залгасан жишээ:

а. Эгшгээр төгссөн үгэнд:

зээлэ- (Mo. jigele-) < Ch. 借 jie “зээлэх”

б. -н(г) төгсгөлтэй үгэнд:

чагна- < чин(г)на- (Mo. čingna-) < tingla- (AT. tñgla-)¹⁵ < Ch. 聽 ting “чагнах”

шагна- < шан(г)на- (Mo. šangna-) < шан(г) (Mo. šang) < Ch. 賞 shang “шагнах”

жигнэ- < жин(г)нэ- (Mo. jingne-) < Ch. 蒸 zheng “жигнэх”

в. -н төгсгөлтэй үгэнд:

цэгнэ- < цэн(г)нэ- (Mo. čengne-) < цэн (Mo. čen) < Ch. 錢 qian “зоос, мөнгө”

тагна- < тан(г)на- (Mo. tangna-) < Ch. 探 tan “хайх, тагнах”

гагна- < ган(г)на- (Mo. γangna-) < Ch. 鉗 han “гагнах”

Хятад гаралтай үгээс хэрхэн үйл үг бүтээх талаар орчин цагийн монгол хэл, Миньхэ монгол хэл хоёрыг харьцуулан үзэж дүгнэвэл, орчин цагийн монгол хэлний -ла- (~ -на-) дагавар, Миньхэ монгол хэлний -ла- (~ -huo- ~ -li- ~ -lie-) дагавар хоёр нь эртний монгол хэлний ижил *-la-/-le- дагавраас гарал үүсэлтэй гэдгээр адил талтай боловч Миньхэ монгол хэлэнд *ki- “хий-” хэлбэрээс үүсэлтэй бас нэг -ke- дагавар хэрэглэдэг байхад орчин цагийн монгол хэлэнд хятад гаралтай үгээс үйл үг бүтээх *-ki- “хий-” дагавар гэж ер байхгүйгээрээ ялгаатай байна.

Монгол хэлний нийлмэл үг бүтээх хий- хэлбэрийн учир

Орчин цагийн монгол хэлэнд хий- гэсэн үйл үгийн утгыг дотор нь 1. үйлдэх (to do), 2. бүтээх (to make), 3. юмыг сав суулга зэрэгт агуулах (to put) гэх мэтээр наанадаж гурав хувааж болох бөгөөд энд зөвхөн 1. үйлдэх (to do) гэсэн утгаар хэрхэн “N хий-”¹⁶ бүтэцтэй нийлмэл үйл үг¹⁷ бүтээх тухай хэлбэр судлалын үүднээс гурав хувааж доор товч дурдъя.

а. N хий- < V (Үйл үгийг нэр үг болгож, дээр нь үйл үг хий- залгасан жишээ):

эмчилгээ хий- (< эмчлэ-), судалгаа хий- (< судал-), бэлтгэл хий- (< бэлтгэ-)

бичлэг хий- (< бич-), цэвэрлэгээ хий- (< цэвэрлэ-), ярилцлага хий- (< ярилца-)

б. N хий- ~ N-ла- (Нэр үгэнд үйл үг хий- залгасан бүтэц нь нэр үгэнд -ла- дагавар залгасан бүтэцтэй сэлгэдэг жишээ):

ажил хий- (~ ажилла-), ан хий- (~ агна-), аян хий- (~ аяла-)

багш хий- (~ багшла-), бүжиг хий- (~ бүжиглэ-), засвар хий- (~ засварла-), тайлбар хий- (~ тайлбарла-), хулгай хий- (~ хулгайла-), хурим хий- (~ хуримла-)

в. N хий- (≠*N-ла-) (Зөвхөн нэр үгэнд үйл үг хий- залгасан хэлбэр л бий бөгөөд тус нэр үгэнд -ла- дагавар залгаж болдоггүй, залгасан ч утга нь тохирдоггүй жишээ):

даалгавар хий- (≠*даалгаварла-), хэрэг хий- “гэмт хэрэг үйлдэх” (≠хэрэглэ-)

дадлага хий- “мэргэжлийн ажил сурахаар урьдчилан ажиллах” (≠*дадлагала-)

Энэ байдлаас үзэхэд орчин цагийн монгол хэлэнд нэр үгэнд үйл үг хий-

¹⁵ Эртний түрэг хэлийг АТ. гэж товчлов.

¹⁶ Нэр үгийг N гэж товчлов.

¹⁷ Үйл үгийг V гэж товчлов.

хэлбэр залгаж нийлмэл үйл үг бүтээх нь түгээмэл тохиолддог ердийн үзэгдэл мөн боловч хятад гаралтай үгэнд огт залгадаггүй (*Ch. хий- хэлбэр байхгүй) гол онцлогтой юм.

Монгол хэлний хий- ~ гэ- сэлгэлтийн учир

Орчин цагийн монгол хэлний зарим дүрслэх үйл үгийн -с дагавар бүхий хэлбэрт үйл үг хий- ~ гэ- залгасан буюу “V-с хий-¹⁸ ~ V-с гэ-” хэлбэрээр *хоромхон үйлдэх байдал* (momentary aspect) илэрхийлдэг бөгөөд энд үйл үгийн хий- ~ гэ- сэлгэх үзэгдэл байгаа нь их сонирхолтой байна. Жишээ нь:

бөхөс хий- ~ бөхөс гэ- (< бөхий-), бохис хий- ~ бохис гэ- (< бохий-)

тонгос хий- ~ тонгос гэ- (< тонгой-), гялс хий- ~ гялс гэ- (< гялай-)

хялс хий- ~ хялс гэ- (< хялай-), өрвөс хий- ~ өрвөс гэ- (< өрвий-) гэх мэт.

Энэ байдлаас үзэхэд орчин цагийн монгол хэлний хий-, гэ- хоёр үйл үг нь үндсэн утгаар эрс ялгаатай ч “агшин зуур болох үйл”-ийн хэрэглээний талаар адил байгаа нь Миньхэ монгол хэлний ge- [гэ-] хэлбэрээр монгол хэлний хий- (Mo. ki-), гэ- (Mo. ge-) хоёр утгыг агуулж байгааг шууд санагдуулна.

Монгол хэлний авиа дуурайх үгээс үйл үг бүтээх -ги- дагаврын учир

Орчин цагийн монгол хэлэнд авиа дуурайх үгээс¹⁹ үйл үг бүтээх -ги- (∞ -гэ-) (Mo. -gi-) дагавар байдаг бөгөөд энэ нь тус авиа дуурайх үгэнд залгасан хий- үйл үгтэй сэлгэх нь олонтоо тохиолдоно.

Оном. -ги- ~ Оном. хий- сэлгэсэн жишээ:

турги- “мал амьтны хамраа дуугаргах” ~ тур тур хий-

шарги- “ус борооны хүчтэй урсан дуугарах” ~ шар шар хий-

царги- “царгиа дуу гарах” ~ цар цар хий-

барги- “баргиа дуу гарах” ~ бар бар хий-

жиргэ-²⁰ “жигжиг шувуудын дуугарах” ~ жир жир хий-

ниргэ-²¹ “цахилгаан цахих” ~ нир нир хий- гэх мэт.

Энэ байдлаас үзэхэд авиа дуурайх үгээс үйл үг бүтээх -ги- (∞ -гэ-) дагаврын гарал үүслийн тухайд гэвэл үйл үг *ki- хэлбэр нь өмнөх авиа дуурайх үгтэйгээ нийлж дагаваржихтай зэрэг *ki- > -gi- зэргээр дуугүй гийгүүлэгч нь дуутай болж хувирсан (k > g) гэж үзэж болох байна.

Орчин цагийн монгол хэлний үйл үг *ki- хэлбэрийн хувьсал

Орчин цагийн монгол хэлний үйл үг *ki- хэлбэрийн тухай дээр 5.1-ээс 5.4 хүртэл дурдсаныг хураангуйлбал доорх мэт:

5.1-ээс хятад гаралтай үгээс үйл үг бүтээх *-ki- “-хий-” дагавар гэж байхгүй.

5.2-оос хятад гаралтай үгэнд үйл үг *хий- залгаж нийлмэл үйл үг бүтээж чадахгүй.

¹⁸ Хоромхон үйлдэх байдал заах энэхүү V-с хий- нийлэмжээс сүүлдээ “түр зуур~, бага зэрэг~” гэсэн утгатай түр үйлдэх байдал (temporary aspect) заах -схий- дагавар үүсэн гарчээ. Шиотани Шигэки (2009), Монгол хэлний халхын аялгуун дахь үг бүтээх дагаврын судалгаа (Засварласан хэвлэл), х.182-184, Осака.

¹⁹ Авиа дуурайх үгийг энд Оном. гэж товчлов.

²⁰ жиргэ- (Mo. jirgi-) гэдэг нь угтаа Мо. -gi- хэлбэртэй үг ажээ.

²¹ ниргэ- (Mo. nirge- < *nir-gi-) гэдэг нь ч угтаа Мо. -gi- хэлбэртэй байсан гэж үзэж байна.

5.3-аас *хоромхон үйлдэх байдал* заах утгаар үйл үг *хий-* ~ *гэ-* хоёр сэлгэх бүрэн боломжтой байна.

5.4-өөс авиа дуурайх үгээс үйл үг бүтээх *-gi-* дагавар нь үйл үг **ki-* “хий-” хэлбэрээс гарал үүсэлтэй байна.

Бас үйл үг **ki-* хэлбэрийн хувьслын явцыг авиазүй болон үгзүйн үүднээс хөөж үзвэл:

А. Бие даасан үгээр *хий-* (дан үг) / N *хий-* (нийлмэл үг) / V-с *хий-* ~ V-с *гэ-* (нийлэмж) гэсэн гурван хэлбэрийг хэрэглэх нь:

**ki-* > ① *ki-* > ② *xi-* (гийгүүлэгч шүргэх, эгшиг урт болсон) / ④ *xi-* ~ *ge-* (сэлгэсэн)

Б. Дагаврын үүргээр *Onom.-gi-* гэсэн хэлбэрийг хэрэглэх нь:

**ki-* > ① *ki-* > ③ *-gi-* (дуутай болсон)

Ер нь авианы түүхэн хувьслыг “ижил нөхцөл байдалд нэг цаг үед адилхан бий болно” гэж үзвэл дээрх авианы хувьслыг ① → ③ → ② → ④ гэсэн дэс дараагаар үүссэн байх гэж таамаглаж болох байна.

Учир нь эхлээд “дагавар”-ын нөхцөл байдалд ① *ki-* > ③ *-gi-* гэх мэтээр дуугүй гийгүүлэгч *k-* нь дуутай *g-* болсон хойно, дараа нь бусад нөхцөл байдал буюу “бие даасан үг”-энд ① *ki-* > ② *xi-* гэх зэргээр хамжих гийгүүлэгч *k-* нь шүргэх *x-*, бас богино эгшиг *i-* нь урт эгшиг *i:-* болж хувирсан боломж их байхаас биш, эсрэгээр нь эхлээд ① *ki-* > ② *xi-* гэсэн авианы хувьсал бүрэн үүссэн хойно, дараа нь ① *ki-* > ③ *-gi-* болж хувирах боломж бараг үгүй гэж үзэж байна.

Дүгнэлт

Эртний монгол хэлэн дэх **ki-* “хий-” хэлбэртэй үйл үг нь Миньхэ монгол хэл болон орчин цагийн монгол хэлэнд хэрхэн хувьсаж ирснийг хэлний цуваа цагийн үүднээс, ялангуяа авиазүй болон үгийн бүтцийн талаар судалсан билээ.

Бидний судалснаар Миньхэ монгол хэл, орчин цагийн монгол хэл хоёрыг харьцуулан үзсэний дүнд тодорхой болсон хоёр хэлний адил ба ялгаатай тал нь дараах байдалтай:

1. Адил талаас дурдвал:

а. Авианы хувьсал үүссэн дэс дараа

Миньхэ монгол хэлэнд бие даасан үгээр ① **ki-* > *ge-* [gə-] дуутай болсон, бас дагавраар ② **ki-* > *-ke-* [-kə-] дуугүй хэвээр үлдсэн хоёр үзэгдлийн талаар авианы хувьсал нь ② → ① гэсэн дэс дараагаар үүссэн байхад орчин цагийн монгол хэлэнд бие даасан үгээр ① **ki-* > *xi-* (хий-) шүргэх гийгүүлэгч, урт эгшигтэй болсон, бас дагавраар *Onom.-gi-* хэлбэр нь ② **ki-* > *-gi-* (-ги-) дуутай болсон хоёр үзэгдлийн тухай ч авианы хувьсал нь ② → ① гэсэн дэс дараагаар үүссэн байна. Энэ нь өөрөөр хэлбэл авианы хувьсал үүссэн зүг чигийн хувьд эхлээд дагаврын хэлбэрт, дараагаар нь дан үгэнд тохиолдсон гэсэн утгаар адил талтай байна.

б. **ki-*, **ge-* хоёр үйл үг тохирох, сэлгэх үзэгдэл

**ki-*, **ge-* хоёр үйл үг нь Миньхэ монгол хэлэнд *ge-* [gə-] хэлбэрээр нийлсэн бөгөөд 1. *хий-* (to do), 2. *гэ-* (to say) хоёр утгыг агуулсан “*ижил дуудлагатай үгс*” болсон байхад орчин цагийн монгол хэлэнд *хоромхон үйлдэх байдал* заах утгаар үйл үг *хий-* ~ *гэ-* хоёр сэлгэдэг нь яг ижил үзэгдэл биш ч гэсэн зохих хэмжээгээр төстэй талтай гэж үзэж байна. Харин ч **ki-*, **ge-* хоёр үйл үг нийлэх, сэлгэх нь хэлний ямар үндэслэл дээр байгаа тухай цаашид улам тодруулах хэрэгтэй байна.

в. Хятад гаралтай үгэнд **-la-/-le-* дагавар залгаж үйл үг бүтээх ёс

Хятад гаралтай үгэнд *-la-/-le- дагавар залгаж үйл үг бүтээх ёс нь Миньхэ монгол хэл, орчин цагийн монгол хэлний аль алинд нь түгээмэл тохиолддог гэсэн утгаар адил талтай байна. Миньхэ монгол хэлний -la- (~ -luo- ~ -li- ∞ -lie-) дагавар, орчин цагийн монгол хэлний -ла- (~ -на-) дагавар хоёр нь нэлээн дээр үеэс уламжлагдсан нийтлэг дагавар байсан гэж болох юм.

2. Ялгаатай талаас дурдвал:

а. Дуугүй гийгүүлэгч нь дуутай болсон дэс дараа

Миньхэ монгол хэлэнд эхлээд *ki- > -ke-, дараа нь *ki- > ge- болсон буюу сүүлд дуугүй нь дуутай болсон байхад монгол хэлэнд эхлээд *ki- > -gi- (-ги-), дараа нь *ki- > xi:- (хий-) болсон буюу түрүүнд дуугүй нь дуутай болсон ялгаатай талтай байна.

б. Хятад гаралтай үгэнд *ki- залгаж үйл үг бүтээх ёс

Хятад гаралтай үгэнд *ki- залгаж үйл үг бүтээх ёс нь Миньхэ монгол хэлэнд -ke- дагавраар харьцангуй элбэг тохиолддог байхад орчин цагийн монгол хэлэнд хий- хэлбэрээр огт тохиолддоггүй гэсэн ялгаатай тал байна.

Төгсгөл

Миньхэ монгол хэлний хятад гаралтай үгэнд залгадаг үйл үг бүтээх -ke- [-кэ-] дагаврын тухай бид урьд нь дурдахдаа “Тус дагаврыг хятад гаралтай зарим үгэнд залгаж тухайн үгийн утга бүхий үйл үг үүсгэнэ.[.....] Гэвч эргэн тойрны монгол төрөл хэлнүүд, тухайлбал Баоань, Дуншаан, Канжаа, Хүжү монгол гэх мэтийн хэлний тус байдлыг тодруулахгүйгээр яаран дүгнэж болохгүй нь лавтай”²² гэсэн билээ.

Дээр дурдсан монгол төрөл хэлнүүд дэх энэхүү *ki- хэлбэрийн тухай товч дурдахад²³: Баоань хэл -²⁴ / Ch. -gə-, Дуншаан хэл giə- / Ch. -ɬi- ~ -ji- (∞ -ɬi-), Ch. giə-, Канжаа хэл gi- / Ch. -gi-, Хүжү монгол хэл gi- / Ch. -ki- ~ -gi-, Зүүн ёгор хэл gə- / - гэсэн байдалтай байна.

Энэ нь өнгөцхөн харахад Миньхэ монгол хэлний gə- / Ch. -kə- ~ -ɬi- байдал нь хамгийн түрүүнд Дуншаан хэлнийхтэй их төсөөтэй харагдах бөгөөд тодруулбал хятад гаралтай үгэнд хамжих гийгүүлэгч -kə- дагавар залгах талаар Баоань, Дуншаан, Канжаа, Хүжү монгол хэлтэй ойр, бас тагнайшсан гийгүүлэгч -ɬi- дагавар залгах талаар Дуншаан хэлтэй илүү ойр байгаа нь ажиглагдлаа.

Миньхэ монгол хэл нь монгол төрөл хэлнүүдийн дотроос нэг их гүнзгий судлагдаагүй хэлний нэг. Иймд цаашид тус хэлний үгээс аль болох олныг түүн цуглуулж үгсийн санг баяжуулах нь хойшдын тал бүрийн судалгаанд нэн ач холбогдолтой гэж бодож байна.

²² Шиотани Шигэки (2023), Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын судалгаа, *Frontier of foreign language education*, Vol.6, х.33, Осака.

²³ Ташуу зураасны зүүн талд үйл үг *ki- хэлбэртэй таарах үг, баруун талд нь хятад гаралтай үг (Ch.)-энд залгасан дагавар эсвэл нийлмэл үгийн хэлбэрийг дурдсан болно. Харин хэлний ямар баримт дээр үндэслэж хураангуйлсан тухай тайлбарыг цаасны хэмжээний боломжоос шалтгаалж энд хасав.

²⁴ Баоань хэлэнд “үйлдэх” гэсэн утгатай үйл үг *ki- хэлбэртэй таарах үг байхгүй бөгөөд *ɬar- ~ jar-* (Mo. *jaša-*) гэсэн үгийг хэрэглэдэг байна.

Ном зүй

- Dpal-Idan-bkra-shis, Keith.Slater, et al. (1996), *Language Materials of China's Monguor Minority: Huzhu Mongghul and Minhe Mangghuer*, Sino-Platonic Papers 69, University of Pennsylvania, Philadelphia.
- Jiang Genxiong (2018), "Language contact-based research on the evolution and development of the Minhe dialect of Monguor language", 63-72, *Altai Hakpo* 28, The Altaic Society of Korea, Korea.
- Slater, Keith W. (2003a), *A Grammar of Mangghuer: A Mongolic language of China's Qinghai-Gansu Sprachbund*, Curzon, London.
- Slater, Keith W. (2003b), *Mangghuer, The Mongolic Languages*, 307-324, Routledge, London and New York.
- Тодаева Б.Х. (1973), *Монгорский язык: Исследование, тексты, словарь*, НАУКА, Москва.
- Шиотани Шигэки (2009), *Монгол хэлний халхын аялгуун дахь үг бүтээх дагаврын судалгаа (Засварласан хэвлэл)*, Осака.
- Shiotani Shigeki (2019a), *A Grammar of Monguor Language* (ILCAA Intensive Language Course 2018 "Monguor" Textbook), The Research Institute for Languages and Cultures of Asia and Africa, Tokyo.
- Шиотани Шигэки (2019b), Миньхэ монгол хэлний эгшиг авианы хувьсал хөгжлийг цуваа цагийн үүднээс судлах нь, *Хэл зохиол судлал*, Vol.12 (44), х.98-106, Улаанбаатар.
- Шиотани Шигэки (2021), Миньхэ монгол хэлний гийгүүлэгч авианы хувьсал хөгжлийг цуваа цагийн үүднээс судлах нь, *Монгол хэл зохиол судлалын хөгжил, чиг хандлага (олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл)*, х.146-157, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Улаанбаатар.
- Шиотани Шигэки (2023), Миньхэ монгол хэлний үг бүтээх дагаврын судалгаа, *Frontier of foreign language education*, Vol.6, х.21-38, Осака.

Summary

This paper considers the development of the verb *ki- (to do) in the Minhe Monguor language from a diachronic perspective, compared with Modern Mongolian.

As a result of the research, *ki- (to do) became *ge-* [gə-] as a simple word and *-ke-* [-kə-] as the denominal verbal suffix in forming verbs from words of Chinese origin. Moreover there is another alternation of the suffixes *-ke-* [-kə-] ~ *-qi-* [-tɕi-] which men tend to use more often. In other words these three morphemes have the same origin *ki- and the phonological changes can be explained as occurring in the order 1. *ki- > *-ke-* [-kə-] (voiceless), 2. *ki- > *-qi-* [-tɕi-] (palatalized), and 3. *ki- > *ge-* [gə-] (voiced) etc.

Finally, the similarities and differences between two languages were mentioned in the conclusion.

Хавсралт

Хавсралт 1: Тус өгүүлэлд хэрэглэсэн “Миньхэ монгол хэлний латин үсэг” ба “Олон улсын авианы галиг” (IPA)-ийн тохиролцоог доор үзүүлбэл:

1. Эгшиг

1.1 Богино эгшиг

a [ɑ], o [o], u [u ~ y / ɤ, ʉ, ɯ-гийн дараа], e [ɛ], i [i ~ ɪ / s, ʃ, ɰ-гийн дараа]

1.2 Хос эгшиг

ai [ai], ei [ei], ao [ao], uo [uo], ou [ou], iu [iu], ie [ie], ue [ue], ua [ua], ia [ia]

1.3 Дараалсан гурван эгшиг

iao [iao], uai [uai]

2. Гийгүүлэгч

b [b], p [p], m [m], w [w], d [d], t [t], z [ɗ], c [ʈ], s [s], n [n], l [l], r [r], zh [dʒ], ch [tʃ], sh [ʃ],

j [ɟ], q [tɕ], x [ɕ], y [j], g [g], k [k], h [x], ng [ŋ], gh [ɕ], kh [q]

3. Бусад анхаарууштай дуудлага

en [ɛn ~ m ~ n], er [ɛr], wu [u], si [si], ci [tsi], zi [ɗi], xu [ɕy], qu [tɕy], ju [ɗy]

Хавсралт 2 : Миньхэ монгол хэлний эгшгийн гол онцлогийг Шиотани (2019b) -гийн өгүүллээс эш татан товчхон дурдвал:

1. Үгийн өргөлт нь ямагт үгийн төгсгөлийн үед байдаг.
2. Эгшиг зохицох ёс байхгүй.
3. “a [a], o [o], u [u], ɛ [ɛ], i [i ~ ɪ]” гэсэн үндсэн 5 эгшигтэй байхаас биш, урдуурх уруулын эгшиг *ō, *ü юм уу, хойгуурх уруулын бус эгшиг *i гэж байхгүй.
4. “iao [iao], uai [uai]” гэсэн 2 төрлийн дараалсан гурван эгшигтэй байна.
5. Урт эгшиг нь богино эгшиг, хааяа хос эгшиг болсон буюу урт, богино эгшгийн ялгаа байхгүй болсон байна.
6. Эртний монгол хэлний үгийн битүү үе нь Миньхэ Монгол хэлэнд ерөнхийдөө задгай үе болох хандлагатай байна.
7. Үгийн бүтэц дэх үеийн тоо багасах хандлага түгээмэл байна.